ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2023 оны 6 сар

2023.08.07

БАНКНЫ САЛБАРЫН ӨСӨЛТ

- Банкны салбарын нийт активын сүүлийн 10 жилийн дундаж өсөлт 14.9 хувь байна.
- Хэвийн зээл 21.6 их наяд буюу нийт активын 45.1 хувийг эзлэж байна. Хэвийн зээлийн дүн өмнөх сартай харьцуулахад 5.4 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.8 хувиар өссөн байна.
- Аж ахуйн нэгж, иргэдийн харилцах өмнөх сартай харьцуулахад 4.9 хувиар өссөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.8 хувиар өссөн байна. Харин нийт хадгаламж өмнөх сартай харьцуулахад 2.3 хувиар өссөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7 хувиар өссөн байна.

2022 он гарснаар бодлогын хүүг 6 удаа нэмж, 13%-д хүргэсэн нь хүүгийн түвшинг цаашид үргэлжүүлэн өсгөх нь тодорхой боллоо.

(их наяд төгрөг)

(их наяд төгрөг)



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

ЗЭЭЛИЙН ЧАНАР

- 2023 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 25.4 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 4.3 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдэлийн 20.7 хувийг бөөний болон жижиглэн худалда, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын, 13.8 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээлийн үлдэгдэл тус тус эзлэж байна.
- Хэвийн зээл 21.6 их наяд буюу нийт активын 45.1 хувийг эзлэж байна. Хэвийн зээлийн дүн өмнөх сартай харьцуулахад 5.4 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.80 хувиар өссөн байна.
- Харин чанаргүй зээлийн хувь 8.6 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад -0.5 нэгж хувиар буурсан , өмнөх оны мөн үетэй харьцуулахад -0.3 нэгж хувиар буурсан байна.

Уул уурхай, олборлолтын салбарын зээлийн үлдэгдэл
Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын
Барилгын салбарын зээлийн үлдэгдэл
Бөөний болон жижиглэн худалда, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын
Үл хөдлөх хөрөнгийн салбарын зээлийн үлдэгдэл
Бусад



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХҮҮ

Зээлийн хүү

Эх сурвалж: Монгол Банк-Сарын бюллютень

» Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүгийн жигнэсэн дундаж нь 16.3 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.1 нэгж хувиар буурсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 нэгж хувиар өссөн байна.

» Харин шинээр олгосон валютын зээлийн хүүгийн жигнэсэн дундаж нь 9.8 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.3 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 нэгж хувиар өссөн байна.

Хадгаламжийн хүү

Эх сурвалж: Монгол Банк-Сарын бюллютень

» Шинээр татсан валютын хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж нь 2.9 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад -0.4 нэгж хувиар буурсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 нэгж хувиар өссөн байна.

» Харин шинээр татсан хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж нь 11.8 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.6 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.3 нэгж хувиар өссөн байна.

АШИГТ АЖИЛЛАГАА

- 2023 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар өөрийн хөрөнгө 5.0 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 8.8 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.9 хувиар өссөн байна.
- Тухайн оны ашиг, алдагдал 0.6 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 35.2 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7 хувиар өссөн байна.



- 2023 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж 21.3 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад -0.6 нэгж хувиар буурсан , өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 нэгж хувиар өссөн байна.
- Нийт хөрөнгийн өгөөж 2.2 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.1 нэгж хувиар өссөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 нэгж хувиар өссөн байна.



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

» 2023 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл 6.9 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.2 хувиар өссөн байна. Нийт нийт ипотекийн зээлийн үлдэгдэлийн 0.9 хувийг ипотекийн хугацаа хэтэрсэн зээл, 0.2 хувийг ипотекийн хэвийн бус зээл тус тус эзлэж байна.

» Ипотекийн хугацаа хэтэрсэн зээл өмнөх сартай харьцуулахад 4.6 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 87.9 хувиар өссөн байна.

Ипотекийн хэвийн бус зээл өмнөх сартай харьцуулахад 1.9 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад -8.0 хувиар буурсан байна.

(их наяд төгрөг)

110,604

Нийт зээлдэгчийн тоо

их наяд төгрөг

6.91

Нийт зээлийн үлдэгдэл



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

БОДЛОГЫН ХҮҮ

» Төв банкнаас арилжаалж буй хамгийн богино хугацаатай үнэт цаасны хүүг бодлогын хүү гэнэ. 2023 оны 3 сарын 15-ны өдөр Монголбанк гадаад эрсдэл, тодорхой бус байдал өндөр байгаа өнөөгийн нөхцөлд Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг хэвээр хадгалах, хүүний коридорыг нарийсгах болон банкны гадаад зах зээлээс шинээр татсан 360 хоног хүртэлх хугацаатай эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох бодлогын шийдвэр гаргав. Энэхүү бодлогын арга хэмжээ нь төгрөгийн өгөөжийг хадгалах болон банкны гадаад валютын эх үүсвэр татах хөшүүргийг бий болгосноор эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах, улмаар инфляцыг зорилтот түвшин рүү илүү хурдан бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

ХОЛБОО БАРИХ

С.ТҮВШИНЗАЯА
Дотоод зах зээл
хариуцсан дэд захирал

+976 9912-2583
tuvshinzaya@tavanbogdcapital.com

А. ДОВДОННЯМ
Дотоод арилжааны
менежер

+976 9400-4442
dovdonnyam.a@tavanbogdcapital.com

У.НОМИН
Шинжээч

+976 9400-0889
nomin.uu@tavanbogdcapital.com

Б.ОТГОН
Бондын брокер

+976 9510-2229
otgon.b@tavanbogdcapital.com

М.ХУЯГАА
Клерк

+976 9502-4664
khuyagaa.m@tavanbogdcapital.com

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭЛТЭС